



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 13 болон 14 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 04-р сарын 02-ноос 04-р сарын 15-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 6 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Олон Улсын Валютын Сангийн 4-р сарын “Дэлхийн Эдийн Засгийн Төлөв” тайланд дэлхийн эдийн засаг энэ онд 6.0 хувиар өсөхөөр төсөөлжээ.** Энэ нь 1-р сарын төсөөллөөс 0.5 нэгж хувиар сайжирсан үзүүлэлт юм. Төсөөллийг сайжруулахад АНУ-ын Засгийн газрын 1.9 их наяд ам.долларын тусламжийн багц батлагдсантай холбоотойгоор АНУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв 5.1 хувиас 6.4 хувь болж нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Мөн БНЭУ-ын өсөлтийн төлөвийг 11.5 хувиас 12.5 хувь, БНХАУ-ын төлөвийг 8.1 хувиас 8.4 хувь болгож нэмэгдүүлсэн байна. Цар тахлаас сэргийлэх зорилгоор улс орнуудын засгийн газрууд нийт 16 их наяд ам.долларын дэмжлэгийг олгоогүй байсан бол 2020 оны дэлхийн эдийн засаг 3.3 хувиар агшсан гүйцэтгэлээсээ даруй 3 дахин ихээр агших байсан тооцоолол гаргажээ.
- **Евро бүсийн улс орнууд цар тахалтай тэмцэх зорилгоор төсвийн зардлыг ДНБ-ий 3 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай** байгааг ОУВС анхаарууллаа. ОУВС-гийн төсөөллөөр Евро бүсийн эдийн засаг энэ онд 4.4 хувь, 2022 онд 3.8 хувиар өсөх тооцоололтой байгаа нь худалдааны түнш орнуудтай харьцуулахад эдийн засаг хамгийн удаан сэргэж буй бүс болохоор байна. Европын томоохон улс орнууд эдийн засгийг сэргээх хөтөлбөрт 2020 онд ДНБ-ий 7.5 хувьтай тэнцэх дэмжлэгийг зарцуулсан бол энэ онд ДНБ-ий 6.5 хувь болгон бууруулахаар байна. Европын Төв банкны ерөнхийлөгч Кристиан Лагард АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлж буй 1.9 их наяд ам.долларын эдийн засгийг сэргээх хөтөлбөр нь Евро бүсийн ДНБ-ийг энэ онд 0.3 хувиар өсгөх бол 2023 онд инфляцыг 0.15 нэгж хувиар өсгөх нөлөөтэй тухай мэдээллээ.
- **АНУ-ын эдийн засаг хурдтай сэргэж, 2021 онд эдийн засаг 6-7 хувиар өсөх, ажилгүйдлийн түвшин 4-5 хувьд хүрч буурах төсөөлөлтэй** байгааг Холбооны нөөцийн банкны тэргүүн Жероми Повелийн 4-р сарын 12-нд өгсөн ярилцлагандаа дурджээ. Мөн Холбооны Нөөцийн банк 2023 он хүртэл бодлогын хүүгээ одоогийн түвшинд хадгалж, мөнгөний зөөлөн бодлогыг үргэлжлүүлэхээ мэдэгдээд байна. Төв банк инфляц 2 хувиас давах эсэхэд хүлээцтэй хандаж байгаа бөгөөд



инфляцын дундаж 2 хувиас давсан тохиолдолд л бодлогын хүүгээ өсгөхөөр байна.

- **ОPEC+ 4-р сарын тайландаа 2021 онд газрын тосны нэг өдрийн эрэлт дунджаар 5.96 сая баррельд хүрэх төсөөллийг хийв.** Энэ нь өмнөх сарын төсөөллөөс нэг өдрийн эрэлт 70 мянган баррелиар нэмэгдэх тооцоолол юм. Улс орнууд хөл хориогоо сулруулан, вакцинжуулалт эрчимжиж буй нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил нэмэгдэх нь газрын тосны үнэ өсөхөд голлон нөлөөлнө гэж таамаглаж байна. Brent төрлийн газрын тосны үнэ 4-р сарын 5-ны байдлаар 62.1 ам.доллар/баррель байсан бол 4-р сарын 14-ний байдлаар 7.1 хувиар өсч 66.6 ам.доллар/баррельд хүрээд байна. АНУ-ын шинэ засаг захиргаа Саудын Арабыг эрчим хүчний үнийг зохистой түвшинд байлгахыг уриалсны дараа ОPEC+-ийн Өргөтгөсөн бүлэг энэ оны **5-р сараас газрын тосны олборлолтоо нэмэгдүүлэхээр** шийдвэрлээд байна. Тухайлбал Жое Байдены эрчим хүч хариуцсан нарийн бичгээр шинээр томилогдоод буй Женнифер Гранхолм Саудын Арабын Эрчим хүчний сайд хунтайж Абдулазиз Бин Салмантай утсаар ярьсан бөгөөд өөрийн твиттер хуудаснаа “Хэрэглэгчдэд хямд, найдвартай эрчим хүчний эх үүсвэрийг бий болгоход олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг бид дахин нотоллоо” хэмээн бичсэн байна. Энэ нь ОPEC+ уулзалтын уур амьсгалыг өөрчилсөн байж болзошгүй гэж шинжээчид таамаглаж байна. ОPEC+ ирэх уулзалт 4-р сарын 28-нд болно.
- **Канадын үл хөдлөх хөрөнгийн холбооны мэдээлснээр** өмнөх оны мөн үетэй харьцуулахад энэ оны 2-р сарын байдлаар **орон сууцны үнэ 25 хувиар**, борлуулалтын хэмжээ 39.2 хувиар тус

тус өсч, **үл хөдлөхийн дундаж үнэ 678 мянган ам.долларт** хүрчээ. Орон сууцны үнийн өсөлтийг хязгаарлахын тулд ипотекийн зээл олгоход иргэдэд тавих шаардлагыг чангатгах саналыг Канадын санхүүгийн зохицуулах байгууллага гаргасан байна. Ингэхдээ орон сууцны зээл хүсэгчид доод тал нь 5.25 хувийн хүүтэй зээлийг төлөх чадамжтай гэсэн санхүүгийн баталгаа гаргах ёстой юм байна. Харин Канадын **орон сууцны зээлийн хүү жилийн одоогоор 4.79 хувь** байгаа нь түүхэн доод түвшинд хүрсэн үзүүлэлт юм.

- **Их Британийн эдийн засаг 2-р сард өслөө.** Бизнес эрхлэгчид хөл хорио болон Brexit-ийн шинэ хилийн хязгаарлалтад дасан зохицож, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болсноор **эдийн засгийн өсөлт 2-р сард 0.4 хувьд хүрсэн тухай** тус улсын Үндэсний статистикийн газар мэдэгдлээ. Гэвч 0.4 хувийн өсөлт нь Ройтерс агентлагийн санал асуулгад оролцсон эдийн засагчдын таамаглал 0.6 хувиас бага байв. Түүнчлэн, бөөний болон жижиглэн худалдаа өсөлттэй байсан тул үйлчилгээний салбар 2-р сард 0.2 хувиар өсчээ.

Эх сурвалж:

1. The Economic Times, [OPEC raises 2021 oil demand growth forecast on hope pandemic wanes](#)
2. Bloomberg, [Housing-Bubble Fear Spurs Canada to Weigh Tighter Mortgage Rules](#)
3. CBS news, [Fed Chair Jerome Powell tells 60 Minutes America is going back to work](#)
4. CNBC news, [OPEC raises 2021 oil demand growth forecast on hope pandemic wanes](#)
5. IMF, [Global economy on firmer ground, but with divergent recoveries amid high uncertainty](#)
6. Financial Times, [IMF urges eurozone to boost spending to fuel economic recovery](#)
7. J.P.Morgan, [2021 Global Market Outlook: What Lies Ahead in the Post-COVID-19 World?](#)
8. WATE, [IMF upgrades forecast for 2021 global growth to a record 6%](#)

- АНУ-ын энэ оны эдийн засгийн өсөлтийн төлөв нэмэгдсэнээр **БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл сайжрах хүлээлттэй байна.** ОУВС АНУ-ын 2021 оны өсөлтийн төсөөллөө 11-р сард 3.9 хувиас 4-р сард 6.4 хувьд хүргэж нэмэгдүүлсэн бол Блүүмбергийн шинжээчид дундаж төсөөллөө 11-р сард 3.5 хувиас 4-р сард 7.7 хувьд хүргэж нэмэгдүүлжээ. Блүүмберг Экономиксийн “NiGEM” загварын тооцооллоор АНУ-ын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл өмнөх төсөөллөөс 2 нэгж хувь болон түүнээс дээш хувиар сайжрах хандлагатай байгаа бөгөөд АНУ-ын эдийн засгийн төсөөлөл 2 нэгж хувиар сайжрах тохиолдолд БНХАУ-ын эдийн засгийн төсөөлөл 0.3 нэгжээр нэмэгдэх эерэг нөлөөтэй байна. Харин АНУ-ын эдийн засаг хүлээлтээс өндрөөр 4 нэгж хувиар сайжирч, 2021 онд 7 хувийг давсан тохиолдолд БНХАУ-ын өсөлт төсөөллөөс 0.6 орчим нэгж хувиар нэмэгдэх төлөвтэй. Улмаар БНХАУ-ын эдийн засаг 2021 онд 9.3 хувиар өсч, Ерөнхийлөгч Ши Жинпиний өсөлтийг 6 хувиас давуулах зорилт биелэхээр байна. АНУ-ын өсөлт 7 хувийг давах тохиолдолд Азийн бусад улс орнууд болох Вьетнам, Индонез болон Өмнөд Солонгост эерэгээр нөлөөлж тус улсуудын эдийн засгийн өсөлтийг ойролцоогоор 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байна.
- БНХАУ-ын дотоод эдийн засгийн идэвхжил 3-р сард тогтвортой сэргэв. Үүнд:
 - **БНХАУ-ын албан ёсны боловсруулах үйлдвэрлэлийн PMI индекс** 2021 оны 2-р сард 50.6 байсан бол 3-р сард хүлээлтээс өндрөөр өсч 51.9-д буюу Цагаан сараас хойшхи хамгийн өндөр түвшинд хүрэв.
 - **10 хотын метро болон замын хөдөлгөөний систем дэх зорчигчдын тоо** 2-р сард цар тахлын өмнөх үеийн түвшнээс 15 хувиар буурч байсан бол 3-р сард цар тахлын өмнөх үеийн түвшнээс 2 хувиар бага түвшинд хүрч, бууралт нь багасав.
 - **Блүүмберг байгууллагын урьдчилсан тооцооллоор 3-р сард** үл хөдлөх хөрөнгө, аж үйлдвэрлэл болон жижиглэн худалдааны салбарууд өмнөх оны мөн үеэс 24 хувь, 16 хувь, 27 хувиар тус тус нэмэгджээ.
 - **БНХАУ-ын Ардын банк** 4-р сарын 14-нд 150 тэрбум юань буюу 23 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний юанийг дунд хугацааны зээлийн хэрэгслээр (medium-term lending facility) дамжуулан мөнгөний захад нийлүүлэв. Энэ нь 4-р сарын 15-ний өдөр хугацаа нь дуусч буй 100 тэрбум юань, 4-р сарын 25-нд хугацаа нь дуусч буй 56 тэрбум юанийг орлохуйц нийлүүлэлт болов. БНХАУ-ын ардын банк цаашид мөнгөний бодлогоо нормалчлах зарчим баримтлан, бодлогын төлөвөө алгуур чангаруулах хүлээлттэй байна.
 - **Гадаад худалдааны тэнцэл 3-р сард ашигтай гарсан хэдий ч өмнөх сараас буурав.** БНХАУ-ын экспорт оны эхний 2 сард жилийн 60.6 хувиар өссөн бол 3-



р сард жилийн 30.6 хувиар өсчээ. Харин импорт 3-р сард жилийн 38.1 хувиар өссөн нь 2018 оноос хойшхи хамгийн өндөр өсөлт байв. Улмаар 2-р сард 37.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан БНХАУ-ын худалдааны тэнцэл 3-р сард 13.8 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. БНХАУ-ын экспортын өсөлт өмнөх сараас удаашрахад эмнэлгийн бүтээгдэхүүн хэрэгслүүдийн экспорт болон электрон барааны экспорт 2020 оны 4-р улирлын дундаж түвшнээс буурсан нь голлон нөлөөлөв. Харин зэсийн импорт 2020 оны 4-р улирлын дундаж 1.8 сая тонноос 2021 оны 3-р сард 2.17 сая тонн хүрч нэмэгдсэн, түүхий нефтийн импортын биет хэмжээ өмнөх оны 4-р улирлын дундаж түвшнээс 18 хувиар тус тус нэмэгдсэн нь тайлант хугацаанд БНХАУ-ын импорт огцом өсөхөд голлон нөлөөллөө.

- Монгол улсад цар тахлын тархалт нэмэгдэж буй нөлөөгөөр БНХАУ-ын

гаалийн хяналт шалгалт чангарч, Монголоос импортлох нүүрсний импортод хязгаарлалт тавих болсноор 4-р сарын 10-ны байдлаар Ганцмод боомтоор нэвтрэх машины тоо 19 хүрч буурав. Харин Шивээхүрэн боомт дээр нүүрсний тээврийн жолоочоос КОВИД-19-ийн халдвар илэрснээр тус боомтоорх нүүрсний тээврийг түр зогсоогоод байсан бол 4-р сарын 2-ны өдрөөс тээвэрлэлтийг эхлүүлсэн хэдий ч тус боомтоор өдрийн 100 хүрэхгүй тооны машин нэвтэрч байна.

Эх сурвалж:

1. *Asia Insight: Biden's Stimulus to push Xi's GDP growth above 9%, Bloomberg*
2. *China Preview: March Industrial Production Likely rose 16% YoY, Bloomberg*
3. *China React: Exports strong, structural shift signals risks, Bloomberg*
4. *Fenwei Coal weekly update, Sxcoal.com*

3

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/04/14	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	9080	0.0%	0.7%	-0.9%	17.2%	78.7%	Дэлхийн нийтээр КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж буйн зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс бага зэрэг нэмэгдэхэд нөлөөлөв.
Төмрийн хүдэр	160	0.0%	1.8%	2.1%	5.1%	92.6%	БНХАУ улс энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй. Иймээс үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс бага зэрэг нэмэгдлээ.
Алт	1736	0.6%	-0.5%	0.9%	-8.0%	1.7%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт хийгдэж буй нь зах зээлд дэх тодорхой бус байдлыг бууруулах нөлөө давамгайлж алтны үнэ өмнөх долоо хоногоос буурахад нөлөөллөө.
Газрын тос (Брент)	66.5	0.0%	5.3%	-3.4%	30.3%	140.3%	ОПЕК+-ийн нэгдэл 4-р сарын 28-нд болох ээлжит хурлаараа нийлүүлэлтээ төдийлөн нэмэгдүүлэхгүй гэсэн хүлээлт газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна. Түүнчлэн ОПЕК+-ийн нэгдэл энэ онд газрын тосны эрэлт 6.6 хувиар нэмэгдэнэ гэсэн нь үнийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлж байна.